

АЛАШААГИЙН ЯРУУ НАЙРАГЧ ЗҮҮНГАР БУЯНБАТЫН ЯРУУ НАЙРГИЙН ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГ: “ЦАГ ХУГАЦАА”-НИЙ АЙ БА УРАН ДҮРСЛЭЛ

Ли Ли (Li Li / 丽丽, МУИС-ийн утга зохиол судлалын хөтөлбөрийн докторант)

Буянбат БНХАУ-ын ӨМӨЗО-ы Алашаа аймгийн Алашаа баруун хошууны Тамсагбулаг сумын уугаал, Зүүнгар овогтой. Тэр бээр ардын багш мөртөө БНХАУ-ын зохиолчдын эвлэлийн гишүүн, БНХАУ-ын цөөн тоот үндэстний зохиолчдын эвлэлийн гишүүн, БНХАУ-ын дөрөвдүгээр удааны найман муж орны “Тэнгэрийн ботго” яруу найргийн наадмын тэргүүн байр, БНХАУ-ын “Дорно” ба ӨМӨЗО-ы “Солонго” шагналт зохиолч. “Есөн эрдэнийн аялгуу”, “Яруу найргаар тайтгарахуй”, зэрэг олон шүлгийн түүвэр хэвлүүлсэн.

Буянбатын “Есөн эрдэнийн аялгуу” хэмээх шүлгийн түүврийн “Жангарын туулиас алдуурсан аялгуу” хэмээх найраглалд Алашаа түмний түүхийг уран сайхнаар илэрхийлэх эхлэлээ болгож, тухайн газар нутгийн онцлог, цаг хугацаа орон зайн хураангуйлал, амьдрал ба уран сайхны үнэний гогцоо дэгээн дээр илэрхийлсэн юм. Цаашлаад энэхүү эхлэлийг бүр тодруулж, говь ахуйн дүрслэлийн задлан дээр нэмж утга зохиол дахь цаг хугацаа, орон зайн айг бүрэлдэн буй болж нэгэн цул утгыг илэрхийлсэн байна. Түүний энэхүү уран зохиолын цаг хугацааны айг ашиглаж өнгөрсөн, одоо, ирээдүйг холбон үзүүлэх, эс бөгөөс ертөнцийн цаг хугацаа хэмээх гайхамшигт ид шидтэй зүйлийг эгэл амьдралын үйл явдалд холбон гүнзгий утга, нарийн мэдрэмжийг дүрсэлсэн олон шүлэг зохиолууд түүний дараагийн товхимол болох “Яруу найргаар тайтгарахуй” номинд олон байна. Жишээ нь “Аргил шаргал бууц минь” хэмээх шүлэгт Алашаагийн хөдөө хээр буйд газар орших нэгэн айлын гэрийн буйрын дэргэд уянгын би баатар бодол бодон шүлэг тэрлэхдээ алс тэртээх цаг хугацааны Агваандандар, Цаянжамц, Нацагдоржийг бодон сүсэглэж байгаа нь тэр цагаас нааш Алашаагийн яруу найргийн охин тэнгэр тасраагүй явсан, үргэлжлэл нь би байна гэх түүхийн урт мэдээллийг товчхон уянгын дүрслэлээр илэрхийлсэн, өөрөөр хэлбэл Агваандандар, Цаянжамц, Нацагдорж нарын амьдарч байсан цаг үеийн уншигчдад сануулж цаг хугацаагаар аялуулсан хэрэг. “Аяа миний Агваандандар ах минь” хэмээх шүлэгт уянгын би баатар өнөө цагийн амьдралын болохгүй бүтэхгүй зүйлд бухимдан бачуурахдаа цаг хугацааны алсад буй нутгийн мэргэн ах Агваандандарт хандсан яруу хандалтаар шүлэгт дөрвөн мөртийг бүтээсэн бөгөөд ингэхдээ Агваандандарын цаг хугацаанд очиж, тэр үеийн монгол ахуйг бүтээсэн нь урлах эрдмийн бас чухал нээлт мөн. Нөгөө “Яриг цагаан ингэний сариг цагаан ботго” хэмээх шүлэгт монголын эзэнт гүрэн байгуулагдсан найман зуун жилийн түүхэн цаг хугацааг Бурхан Халдун уултай холбон, монгол ахуй амьдралыг өнчин цагаан ботго, түүний эхтэй уян, үндэсний бахархал болсон морин хуураар илэрхийлэн асар өргөн санаа, гүн утга, цаг хугацааны урт түүхийг маш богино, уянгын, тод, мэдрэмжтэй дүрслэлээр “хуурын хоёр чавхадсан дээгүүр эх ботго хоёр найман зууны турш тэшээр өнөө бидний говь нутагт үлдсэн” гайхалтай санааг урлажээ. Энэ бол яруу найрагчийн утга зохиол дахь цаг хугацааны айг уран дүрслэлд ашигласан нэгэн гайхалтай уран арга маяг мөн юм. “Алдагдсан хайрын хойноос” хэмээх шүлэгт Алашаа баруун хошууны газар нутгийн ихэнхийг эзэлдэг “Бадайн жаран” хэмээх гайхамшигт элсэн цөл говь нутгийн хүн ардын туулж өнгөрүүлсэн гунигтай амьдралын хар барааныг хүнчлэн үзүүлсэн нь бас л сонин дүрслэл. Дөрвөн мөртөд орсон “буурал үрчлээс”, “багтарсан шар салхи”, “балгаж орохгүй хундага дарс”, “бараан саарал гуниг” гэсэн үгнүүд нь зохиогчийн сэтгэлийн мухраас ундран гарсан, өвөг дээдэс, эцэг эхийн амьдралын сургамжаас үүдсэн түүхэн үнэн, өнөө үеийн амьдралд харагдах яруу найрагчийн торгон мэдрэмжийн илэрхийлэл болж эдгээр нь бүгд нийлэн яруу найрагчаас уншигч түмэнд хандсан сэтгэлийн нээлт, зүрхний үг болон харагдаж байна.